



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2016 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 45

Мандалговь

Г

Хөрөнгө шилжүүлэх тухай

Т

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймаг болон сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн нийт 194,996,042 /нэг зуун ерэн дөрвөн сая есөн зуун ерэн зургаан мянга дөчин хоёр/ төгрөгийн хавсралт дахь хөрөнгийг “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ны харъяа “Говьсүмбэр аймгийн Цахилгаан түгээх сүлжээ салбар”-т шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Үндсэн хөрөнгийг зохих журмын дагуу данс бүртгэлд бүртгэж авахыг аймгийн Цахилгаан түгээх сүлжээ салбарын дарга Т.Отгоншагайд даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч С.Ууганбаярт үүрэг болгосугай.

ДАРГА

С.СҮХБААТАР





Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 сарын 16 өдрийн 28 дугаар тогтоолын хавсралт

Шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

№	Сумын нэр	Ашиглалтанд орсон огноо	Хөрөнгийн нэр	Үнийн дүн
1	Цагаандэлгэр	2015	0.4 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл	95,037,767.0
2	Өндөршил	2014	0.4 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл	99,958,275.0
Нийт дүн				194,996,042.0